



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



World Health
Organization

Representative Office
for Mongolia

СҮРЬЕЭГИЙН ТАНДАЛТЫН ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ЭМХЭТГЭЛ (2017-2022)

Улаанбаатар

2023 он

АГУУЛГА

СҮРЬЕЭ ӨВЧИН ДЭЛХИЙ ДАХИНД GLOBAL TUBERCULOSIS REPORT 2022	6
--	---

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ МЭДРЭГ СҮРЬЕЭГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	8
1.1 Илрүүлэлт, оношилгоо	9
1.2 СҮРЬЕЭГИЙН ШИНЭ ТОХИОЛДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ	14
1.3 ӨМНӨ ЭМЧЛЭГДСЭН СҮРЬЕЭГИЙН ТОХИОЛДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ	33
1.4 БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД	39
1.5 СҮРЬЕЭГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, АЙМАГ ДҮҮРГЭЭР	50
НЭГДҮГЭЭР БҮЛГИЙН МЭДЭЭЛЛИЙН ХУРААНГУЙ	62

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	68
2.1 РИФАМПИЦИН, ОЛОН ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	68
2.2 НЭГ БОЛОН ЦӨӨН ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	81
ХОЁРДУГААР БҮЛГИЙН МЭДЭЭЛЛИЙН ХУРААНГУЙ	84

ГУРАВДУГААР БҮЛЭГ СҮРЬЕЭГИЙН ИЛРҮҮЛЭЛТ, ЛАБОРАТОРИЙН ОНОШИЛГОО, ЭМЭНД ТЭСВЭРЖИЛТ	86
3.1 ТҮРХЦИЙН ШИНЖИЛГЭЭ, ТҮҮНИЙ ИЛРҮҮЛЭЛТ, ЧАНАРЫН ХЯНАЛТ	87
3.1.2 Түрхцийн шинжилгээний чанарын хяналтын гүйцэтгэл	89
3.2 АЙМАГ	90
3.3 УЛААНБААТАР ХОТ (8 ДҮҮРЭГ)	115
3.4 ХОРИХЫН ЭМНЭЛГҮҮД	127
3.5 ТӨРӨЛЖСӨН НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ТӨВ ЭМНЭЛГҮҮД	130
3.6 ХӨСҮТ-ИЙН СҮРЬЕЭГИЙН ҮНДЭСНИЙ ЛАВЛАХ ЛАБОРАТОРИ	132
3.7 ТҮРХЦИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ГАДААД ҮНЭЛГЭЭ, УР ЧАДВАРЫН СОРИЛ-2022 ОН	133
3.8 ДЭМБ-ЫН ЗӨВЛӨСӨН МОЛЕКУЛЫН ТҮРГЭВЧИЛСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ (ХPERT MTB/RIF(ULTRA)) ГҮЙЦЭТГЭЛ	135
3.9 ХPERT MTB/RIF ШИНЖИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ГАДААД ҮНЭЛГЭЭ	144
3.10 ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭ	145

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АЙМАГ, ДҮҮРГИЙН СҮРЬЕЭГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	149
---	-----

ТАВДУГААР БҮЛЭГ ТАНДАЛТЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД АНГЛИ ХЭЛЭЭР	239
--	-----

Танд энэ өдрийн мэнд хүргэе!

Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ)-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанаас сүрьеэгийн тандалтын тайлан мэдээг цахим болон цаасан бүртгэл, мэдээлэлд үндэслэн үндэсний болон аймаг, дүүргийн сүрьеэгийн үзүүлэлтүүдийг жил тутам эмхэтгэн гаргаж ирсэн билээ.

Энэ удаад бид сүрьеэгийн тандалтын тогтолцооны 2017-2022 оны тайлан мэдээг нэгтгэн дүгнэж, 5 үндсэн бүлэг, 264 хуудас бүхий эмхэтгэл болгон та бүхэнд толилуулж байна.

Сүүлийн 6 жилийн тоо мэдээг нэгтгэн хүргэж байгаа маань санамсаргүй хэрэг биш бөгөөд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын өмнөх 3 жил, цар тахлын үеийн 3 жилийн тоо мэдээг харьцуулан үзэх нь, тандалтын тогтолцоонд үзүүлж буй сөрөг, эерэг нөлөөлөл, үйл ажиллагааны сэргэлтийг үнэлэхэд ач холбогдолтой гэж үзлээ.

Ковид цар тахлын улмаас сүрьеэгийн тусламж үйлчилгээнд багагүй хүндрэл бэрхшээл тохиолдсон бөгөөд сүрьеэгийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний чанар хүртээмж буурсан. Тухайлбал, сүрьеэгийн илрүүлэлт ковидоос өмнө дунджаар 31% байсан бол Ковид цар тахлын үед буюу 2020-2022 онд 24% болж буурсан зэрэг олон олон өөрчлөлтийг та эмхэтгэлээс олж харж болох юм.

Сүрьеэгийн тандалтын тогтолцоонд одоогийн байдлаар цаасан болон цахим бүртгэл мэдээллийг зэрэгцүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд 2024 оноос бид бүрэн цахим руу шилжих зорилго тавин ажиллаж байна. Цахим бүртгэл мэдээллийг бүрэн нэвтрүүлснээр тандалтын тоо мэдээ, дүн шинжилгээ илүү нарийвчлалтай хийгдэж, тухайн цаг хугацаанд нь үр дүнг мэдээлэх, засаж сайжруулах арга хэмжээг богино хугацаанд авч хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

“Сүрьеэгийн тандалтын тайлан мэдээ 2017-2022 он” эмхтгэлийг хэвлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт гүн талархал илэрхийлье. Салбар бүрийн бүхий л түвшний шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчид, мэргэжилтнүүд, мэдээлэл хэрэглэгчдэд нотолгоонд суурилсан үнэн зөв мэдээлэл олгож, сүрьеэгийн тусламж, үйлчилгээнд хувь нэмэрээ оруулах, бусад байгууллага хамт олонтой үр дүнгээ харьцуулахад тань энэхүү эмхэтгэл дэмжлэг үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

**ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны
эмхэтгэл гаргасан ажлын хэсэг**

ТОВЧИЛСОН ҮГС

ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
НДББ	Номхон далайн баруу бүс
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
СТСА	Сүрьеэгийн тангалт судалгааны алба
СҮЛЛ	Сүрьеэгийн үндэсний лавлагаа лаборатори
УБС	Уушгины бус сүрьеэ
ЭТС	Эмэнд тэсвэртэй сүрьеэ
РИФ	Рифампицин
Риф/ОЭТС	Рифампицин/Олон эмэнд тэсвэртэй сүрьеэ
МОЭТС	Маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэ
НЭТС	Нэг эмэнд тэсвэртэй сүрьеэ
ЦЭТС	Цөөн эмэнд тэсвэртэй сүрьеэ
ЦТШ	Цэрний түрхцийн шинжилгээ
ЭШЭ	Эрчимт шатны эмчилгээ
ҮШЭ	Үргэлжлэх шатны эмчилгээ
ХДХВ	Хүний дархлал хомсдлын вирус
РВЭЭ	Ритро вирусын эсрэг эмчилгээ
Н	Изониазид
Р	Рифампицин
Е	Этамбутол
S	Стрептомицин
УБ	Улаанбаатар
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
БГД	Баянгол дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
НД	Налайх дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭХЭМТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
УНТЭ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
УХТЭ	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
УГТЭ	Улсын гуравдугаар төв эмнэлэг



СҮРЬЕЭ ӨВЧИН ДЭЛХИЙ ДАХИНД

GLOBAL TUBERCULOSIS REPORT 2022

GLOBAL TUBERCULOSIS REPORT 2022

СҮРЬЕЭГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

- Сүрьеэ нь агаар дуслын замаар дамждаг халдварт өвчин.

Сүрьеэ нь КОВИД-19-ийн дараах нас баралтад хүргэж буй 2 дахь халдварт өвчин болж байгаа бөгөөд дэлхий дахин дахь нас баралтын 13 дахь шалтгаан болж байна. Мөн ХДХВ-ын халдвар болон антибиотик тэсвэржилтээс үүдэлтэй нас баралтын шалтгааныг тэргүүлж байна.

Сүрьеэ өвчин

- 2021 онд 10.6 сая (9.9-11 сая, 95% итгэх интервал) хүн сүрьеэгээр өвчлсөн. Үүний 6 сая нь эрэгтэй, 3.4 сая нь эмэгтэй, 1.2 сая нь хүүхэд байна. Нийт тохиолдлын 6.7% нь ХДХВ-ын халдвартай хүмүүс байна.
- Сүрьеэгийн өвчлөлийн түвшин (100 мянган хүн амд ноогдсон) 2020-оос 2021 оны хооронд 3.6%-иар өссөн. Сүүлийн 20 жилийн хугацаанд жил бүр 2 орчим хувиар буурч байсан.
- 2005-2019 онуудад сүрьеэгийн нас баралт тогтмол буурч байсан боловч 2019-2021 онд дэлхий дахинд өссөн. 2021 онд 1.6 сая хүн сүрьеэгийн улмаас нас барсан. Үүнээс 187 000 хүн ХДХВ-ын халдвартай байсан.
- Нийт сүрьеэгийн тохиолдлын 2/3 нь дараах найман улс оронд бүртгэгдэж байна: Энэтхэг, Индонез, Хятад, Филиппин, Пакистан, Нигер, Бангладеш болон Бүгд Найрамдах Ардчилсан Конго улс.

Сүрьеэгийн тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэлт


- 2000-2021 онд 74 сая хүний амь насыг сүрьеэгээс хамгаалсан.
- Дэлхий дахинаа 2019 онд 7.1 сая тохиолдол бүртгэгдэж байсан бол 2020 онд 5.8 сая болж буурсан. Харин 2021 онд 6.4 сая тохиолдол болж өсжээ.
- 2018-2021 оны хооронд эмчилгээнд хамрагдсан хүмүүсийн нийт тоо 26.3 сая байсан нь НҮБ-ын Дээд түвшний уулзалтын 5 жилийн (2018-2022) зорилтот 40 сая хүний 66 хувьтай тэнцэж байна. Үүнд 1.9 сая хүүхэд хамрагдсан нь 5 жилийн зорилтот 3.5 сая хүүхдийн 54% юм.
- Сүрьеэгийн өвчлөлийн тооцоолол болон шинээр оношлогдсон тохиолдлын тоо хоёрын хооронд зөрүү байсаар байна. Сүрьеэ өвчнөөр оношлогдоогүй болон бүртгэгдээгүй хүмүүсийн тоо 2019 онд 3.2 сая байсан бол 2021 онд 4.2 сая болж өссөн.

Эмэнд тэсвэртэй сүрьеэ


- 2020-2021 онуудад эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдол өссөн, 2021 онд рифампицин тэсвэртэй 450 000 (399 000-501 000, 95% итгэх интервал) сүрьеэгийн тохиолдол бүртгэгдсэн.
- 2019-2020 онд рифампицин болон олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээний хамрагдалт буурсан. 2021 онд 161 746 хүн эмчилгээнд хамрагдсан нь шаардлагатай тохиолдлын дөнгөж 1/3 байна.
- Эмчилгээний амжилт 60% буюу бага хэвээр байсаар байна.

Сүрьеэ ба ХДХВ-ийн хавсарсан халдвар

- 2021 онд сүрьеэ, ХДХВ-ийн хавсарсан халдвартай 703 000 тохиолдол байгаагаас 46% нь РВЭЭ-нд хамрагдсан байна.
- Сүрьеэ, ХДХВ-ийн хавсарсан халдвар болон эмчилгээнд хамрагдаагүй байдал Африкийн бүс нутагт хамгийн өндөр байна.



КОВИД-19-ийн цар тахал нь сүрьеэтэй тэмцэхэд гарсан ахиц дэвшилд сөргөөр нөлөөллөө. Цаашид ч мөн сүрьеэгийн тусламж үйлчилгээнд сөрөгөөр нөлөөлөхөөр байна.



1.6 сая хүн сүрьеэгийн улмаас нас барсан, үүний 187 000 нь ХДХВ-ын халдвартай хүмүүс байна. Сүрьеэ нь нас баралт хамгийн өндөр халдварт өвчин билээ.

Мөн ХДХВ-ын халдвар болон антибиотик тэсвэржилтээс үүдэлтэй нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна.

2000-2021 онуудад 74 сая хүнийг сүрьеэгээр нас барахаас хамгаалсан.

Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн илрүүлэлт, эмчилгээний хамрагдалт нь нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болоод байна.

Оношлогдсон тохиолдлуудын 36% нь эмчилгээнд хамрагдсан байна.



2022 онд сүрьеэгийн оношлогоо, тусламж үйлчилгээнд 13 тэрбум ам.доллар шаардлагатай байна.

2021 онд 5,4 тэрбум ам.доллар зарцуулсан.

Үүний: 79% нь улсын дотоодын төсөв, 1,1 тэрбум нь олон улсын санхүүжилт байна.

Жил бүр сүрьеэгийн судалгаанд 2 тэрбум ам.доллар шаардлагатай.

Гэвч 1.1 тэрбум доллар дутагдалтай байна.



Оношилгоо, эмчилгээний шинэчлэл

- Сүрьеэг устгах зорилтод хүрэхэд ДЭМБ-аас зөвлөмж болгож буй молекул биологийн хурдавчилсан шинжилгээг ашиглан эрт, үнэн зөв оношлох боломжийг нэмэгдүүлэх нь чухал билээ.
- Хурдавчилсан шинжилгээний хэрэглээ хязгаарлагдмал байна. 2021 онд шинээр оношлогдсон 6.4 сая хүний дөнгөж 38%-д хийсэн нь 2020 онд 33%, 2019 онд 28% байснаас өссөн үзүүлэлттэй байна.
- Рифампицин болон олон эмэнд тэсвэртэй сүрьеэг 109 (2020 онд 92) улс орон урт хугацааны горимоор, 92 (2020 онд 65) улс орон богино хугацааны горимоор эмчилж байна.
- 2021 оны эцсээр 124 улс орон рифампицин тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээнд бедакулин хэрэглэж байна (2020 онд 110).
- Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд рифамицин богино хугацааны (1-3 сар) горимын хэрэглээ нэмэгдсэн. 2021 онд дэлхийн 52 улс оронд 185 350 хүн богино горимоор хамрагдсан гэж бүртгэгдсэн харин 2020 онд 37 улс оронд 25 657 хүн хамрагдаж байжээ.

Судалгаа, инноваци

- Оношилгооны аргууд нь туршилт, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн ачаар нэлээд өргөжсөн. Үүнд сүрьеэ өвчин, эмэнд тэсвэртэй байдлыг илрүүлэх молекулын шинжилгээ, сүрьеэгийн халдварыг илрүүлэх интерферон-гамма шинжилгээ (IGRAs), сүрьеэ өвчнийг илрүүлэх биомаркерт суурилсан шинжилгээ, цээжний рентген зурагт компьютерын тусламжтай сүрьеэ илрүүлэх (CAD) мөн сүрьеэ өвчнийг илрүүлэх шинэ аэрозол технологийн аргууд багтана.
- 2022 онд ДЭМБ нь туберкулины арьсны сорилоос өвөрмөц чанар өндөртэй 3 шинэ антигенд суурилсан сорилыг үнэлэн, зөвлөмж болгосон.
- 2022 оны 9-р сард шинэ вакцин гаргах 16 эмнэлзүйн судалгаа явагдаж байна. Үүний дөрөв нь I үе шатанд, найм нь II шатанд, дөрөв нь III шатанд явагдаж байна. Сүрьеэгийн халдвар болон өвчлөхөөс урьдчилан сэргийлэх, сүрьеэгийн эмчилгээний үр дүнг сайжруулахад чиглэсэн судалгаанууд багтаж байна.
- 2022 оны 9-р сард сүрьеэгийн эмчилгээний 26 эмийг I, II, III үе шатуудад туршилт хийсэн. Эдгээр эмүүдийн 17 нь шинэ химийн бодис ба үүнээс хоёр эм нь зохицуулалтын зөвшөөрөл, нэг эм нь АНУ-ын Хүнс, Эмийн Захиргаанаас бактерийн эсрэг болон мөөгөнцрийн эсрэг эмийн хязгаарлагдмал популяцийн дагуу зөвшөөрөгдсөн мөн зургаан эм нь дахин ашиглах боломжтой эмүүд байна. Сүрьеэгийн халдварыг эмчлэх эм, эмийн горимыг үнэлэх 22 эмнэлзүйн туршилт хийгдсэн.

Бүх нийтийн эрүүл мэндийн хамрагдалт, нийгмийн хүчин зүйлс, олон талт хамтын ажиллагаа



- Сүрьеэгийн тархалтыг бууруулахад нийгмийн хамгааллыг дээшлүүлэх, салбар дундын хамтыг үйл ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байна.
- Сүрьеэгийн улмаас санхүүгийн дарамтад өртөхгүй байх зорилтод хүрэхийн тулд ихээхэн хүчин чармайлт шаардлагатай байна. Сүүлийн үеийн судалгаагаар сүрьеэтэй хүмүүсийн болон тэдний гэр бүлийн 48% (36-61%, 95% итгэх интервал) санхүүгийн дарамтад өртөж байна.
- 2021 онд дэлхий даяар сүрьеэгийн тохиолдлын 2.2 сая нь хоол тэжээлийн дутагдал, 0.86 сая нь ХДХВ-ийн халдвар, 0.74 сая нь архины хамаарал, 0.63 сая нь тамхидал, 0.37 сая нь чихрийн шижинтэй байна.
- ДЭМБ нь 2019-2021 онуудад сүрьеэгийн тархалт өндөр улс орнуудад чуулган болон үнэлгээнээс гарсан зөвлөмжийн дагуу иргэний нийгмийн төлөөлөлтэй хамтран үндэсний төсвийн төлөвлөлтөд хариуцлагын механизмыг тусган ажилласан.
- Сүрьеэгийн тогтвортой хөгжлийн зорилтын 14 үзүүлэлтэд гол анхаарч ажиллаж байна. Эдгээр үзүүлэлтүүдээр үндэсний хэмжээнд сүрьеэ өвчний тархалтын гол нөлөөллийг тодорхойлох цаашид түүнийг таслан зогсооход шаардлагатай салбар дундын хамтын арга хэмжээг мэдээлэхэд ашиглаж болно.

Санхүүжилт




- 2018 оны НҮБ-ын Дээд түвшний уулзалтын зорилтод хүрэхийн тулд 2022 онд сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэхэд 13 тэрбум ам.доллар шаардлагатай.
- 2019 онд сүрьеэгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний зардал 6.0 тэрбум ам.доллар байсан бол 2021 онд 5.4 тэрбум ам.доллар болж буурсан нь дэлхийн зорилтот түвшний талд ч хүрэхгүй үзүүлэлт юм.
- Өмнөх 10 жилийн нэгэн адил 2021 онд сүрьеэгийн тусламж үйлчилгээний зардлын дийлэнх нь (79%) дотоодын эх үүсвэрээс гарсан байна.
- Бага, дунд орлоготой орнуудад олон улсын санхүүжилт нэн чухал хэвээр байна. Гол эх үүсвэр нь Глобал сангийн ДОХ, сүрьеэ, хумхаа өвчинтэй тэмцэх төсөл юм. АНУ-ын Засгийн газар нь Глобал санд хамгийн их санхүүжилт олгодог бөгөөд хамгийн том хөрөнгө оруулагч юм. Энэ нь олон улсын санхүүжилтийн 50 орчим хувийг бүрдүүлж байна.
- Сүрьеэгийн судалгааны санхүүжилтэд хөрөнгө оруулалтын түвшнээс шалтгаалж 2020 онд 0.9 тэрбум ам.доллар зарцуулсан нь жил бүр 2 тэрбум ам. доллар болгох дэлхийн зорилтоос хамаагүй доогуур үзүүлэлт байна.

Урьдчилан сэргийлэх эмчилгээ

- ДЭМБ-аас ХДХВ-ийн халдвартай, нян судлалаар батлагдсан уушигны сүрьеэгийн тохиолдлын өрхийн хавьтал болон эмнэлзүйн эрсдэлт бүлэг (жишээлбэл, диализ хийлгэж буй хүмүүс)-т сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээг зөвлөж байна.
- 2021 онд дэлхий даяар сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд 3.5 сая хүн хамрагдсан нь 2019 оны 3.6 сая хүнээс бага байгаа ч 2020 онд 3.2 сая байснаас нэмэгдсэн байна.
- 2018-2021 онд сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд 12.5 сая хүн хамрагдсан НҮБ-ын 2018-2022 онуудад 30 сая хүргэх зорилтын 42%-д л хүрч байна.
- Урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамрагсдын дийлэнх нь ХДХВ-ийн халдвартай хүмүүс байна. 2018-2022 онуудад ХДХВ-ын халдвартай 6 сая хүнд урьдчилан сэргийлэх эмчилгээ хийнэ гэсэн зорилт биелээд байна.
- 2018-2021 оны хугацаанд сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамрагдсан өрхийн хавьтлын тоо 2.2 сая байна. Энэ нь 2018-2022 онд 24 саяд хүргэх 5 жилийн зорилтын дөнгөж 9.2%-ыг хангаад байна.



2020 оны НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын тайланд сүрьеэг устгах дэлхийн зорилтод хүрэх 10 гол зөвлөмжийг тусгасан болно.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ СҮРЬЕЭГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НЭГ. СҮРЬЕЭГИЙН БҮРТГЭГДСЭН ТОХИОЛДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2022 онд ДЭМБ-аас гаргасан “Global TB report 2021” тайлан мэдээгээр Монгол улсад сүрьеэгийн өвчлөлийн түвшин 100000 хүн амд 428 байгаа нь дэлхий болон НДББ-ийн улс орнуудын дунджаас даруй 3.2-4.4 дахин өндөр байна. Харин эмчилгээний амжилт 90% хүрч дэлхий болон бүсийн дунджаас өндөр байна.

	Сүрьеэгийн тооцоолсон өвчлөл	Эмчилгээний амжилт	
	тоо	100.0 хүн амд	
Дэлхий дахинд	10.6 сая	134	86%
НДББ-ийн улс оронд	1.8 сая	98	88%
Монгол улсад	14 мянга	428	90%

Дэлхий нийтийг хамарсан коронавируст цар тахлын улмаас 2020-2021 онд Монгол улсын сүрьеэгийн тусламж үйлчилгээнд хүндрэл бэрхшээл багагүй тохиолдсон. Тухайлбал, ковидын эсрэг тусламж үйлчилгээнд сүрьеэгийн эмч мэргэжилтнүүдийн 32% нь дайчлагдан ажиллаж, зөөврийн рентген, Gene Xpert аппарат зэрэг оношлогооны тоног төхөөрөмжийн 73%, ажлын байрны 51%-ийг ковидын эсрэг үйл ажиллагаанд ашигласан. Мөн түүнчлэн сүрьеэгийн эмч ажилтан өөрсдөө ковидын халдварт өртсөн, бүх нийтийг хамарсан хөл хорио удаа дараа тогтоогдсон, хүн амын эмнэлэгт хандах хандлага буурсан зэрэг цар тахлын нөхцөл байдал нь сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж дээрх онуудад сүрьеэгийн илрүүлэлт оношилгоо буурсан байна.

2022 онд Ковид-19-ын цар тахлын нөлөөлөл буурч, сүрьеэгийн үндсэн тусламж үйлчилгээ хэвийн байдалд шилжин орсон хэдий ч сүрьеэгийн илрүүлэлт оношилгоонд ахиц дэвшил төдийлөн гарсангүй.

1.1 Илрүүлэлт, оношилгоо

Сүрьеэгийн илрүүлэлт 2017-2019 онд дунджаар 31% байсан бол Ковид цар тахлын үед буюу 2020-2022 онд 24% болж буурсан.

Сүрьеэгийн илрүүлэлтийн хувь 2022 онд аймаг орон нутагт 21.2%, Улаанбаатар хотод 21.3% байгаа нь Ковидын өмнөх 2019 онтой харьцуулахад аймаг орон нутагт 34%, нийслэлд 31% буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1.1.1 Сүрьеэгийн илрүүлэлт, 2017–2022 он

	Тооцоолол	Бүртгэгдсэн						Илрүүлэлтийн хувь					
		2017	2018	2019	2020	2021	2022	2017	2018	2019	2020	2021	2022
Аймгийн дүн	5237	1690	1575	1680	1459	978	1108	32.3	30.1	32.1	27.9	18.7	21.2
УБ-ын дүн	7677	2470	2242	2359	2249	1681	1637	32.2	29.2	30.7	29.3	21.9	21.3
Хорих	168	60	63	50	93	50	58	35.7	37.5	29.8	55.4	29.8	34.5
Улсын дүн	13000	4220	3880	4089	3801	2709	2803	32.5	29.8	31.5	29.2	20.8	21.6

Аймаг орон нутагт сүрьеэгийн илрүүлэлт Ковид цар тахлын өмнө дунджаар 31.5% байсан бол цар тахлын үед буюу 2020-2022 онд 22.6% байна.

2022 онд аймаг орон нутагт сүрьеэгийн илрүүлэлт 2020 оноос 24% буурч, харин 2021 оноос 13.3% өссөн үзүүлэлттэй байна.

2022 онд Дорноговь, Архангай, Дорнод, Сэлэнгэ, Булган, Дундговь, Өвөрхангай Говьсүмбэр, Хөвсгөл зэрэг 9 (43%) аймагт илрүүлэлт 20%-аас доош байгаа бол Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай аймгуудад 30%-аас дээш илрүүлэлттэй байна. Нийт 18 (86%) аймагт илрүүлэлт өмнөх оноос эерэг үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1.1.2 Сүрьеэгийн илрүүлэлт, 2017–2022 он

Аймаг дүүрэг	Тооцоолсон өвчлөл	Бүртгэгдсэн /шинэ+дахилт/						Илрүүлэлт					
		2017	2018	2019	2020	2021	2022	2017	2018	2019	2020	2021	2022
		тоо						хувь					
Архангай	200	55	68	58	68	44	30	27.5	34.0	29.0	34.0	22.0	15.0
Баян-Өлгий	133	40	37	44	38	30	40	30.1	27.8	33.1	28.6	22.6	30.1
Баянхонгор	162	50	64	59	48	36	40	30.9	39.5	36.4	29.6	22.2	24.7
Булган	166	43	36	48	33	27	29	25.9	21.7	28.9	19.9	16.3	17.5
Говь-Алтай	79	21	16	33	31	17	25	26.6	20.3	41.8	39.2	21.5	31.6
Говьсүмбэр	87	28	37	18	18	15	17	32.2	42.5	20.7	20.7	17.2	19.5
Дархан-Уул	597	232	179	172	144	111	123	38.9	30.0	28.8	24.1	18.6	20.6
Дорноговь	294	105	103	92	81	48	41	35.7	35.0	31.3	27.6	16.3	13.9
Дорнод	427	143	148	112	98	58	65	33.5	34.7	26.2	23.0	13.6	15.2
Дундговь	132	41	35	31	30	21	25	31.1	26.5	23.5	22.7	15.9	18.9
Завхан	128	34	50	36	41	26	38	26.6	39.1	28.1	32.0	20.3	29.7
Орхон	313	94	82	90	106	62	67	30.0	26.2	28.8	33.9	19.8	21.4
Өвөрхангай	199	72	42	61	54	41	38	36.2	21.1	30.7	27.1	20.6	19.1
Өмнөговь	84	30	28	36	33	20	23	35.7	33.3	42.9	39.3	23.8	27.4
Сүхбаатар	234	70	71	97	81	54	69	29.9	30.3	41.5	34.6	23.1	29.5
Сэлэнгэ	628	215	169	174	129	96	108	34.2	26.9	27.7	20.5	15.3	17.2
Төв	336	122	101	173	98	67	80	36.3	30.1	51.5	29.2	19.9	23.8
Увс	182	61	44	46	42	33	54	33.5	24.2	25.3	23.1	18.1	29.7
Ховд	143	41	45	50	51	26	44	28.7	31.5	35.0	35.7	18.2	30.8
Хөвсгөл	365	103	109	111	116	67	72	28.2	29.9	30.4	31.8	18.4	19.7
Хэнтий	341	90	111	139	119	79	80	26.4	32.6	40.8	34.9	23.2	23.5
Аймгийн дүн	5237	1690	1575	1680	1459	978	1108	32.3	30.1	32.1	27.9	18.7	21.2

Улаанбаатар хотод сүрьеэгийн илрүүлэлт Ковид цар тахлын өмнө 30.7% байсан бол цар тахлын үед 24.2% байна.

2022 онд Улаанбаатар хотод сүрьеэгийн илрүүлэлт 2021 оноос 3%, 2020 оноос 27% тус тус буурсан байна.

2022 онд илрүүлэлтийн хувь өмнөх онтой харьцуулахад, 5 (56%) дүүрэг буюу БНД, БГД, БЗД, НД, СБД-т буурч, 4 (44%) дүүрэг буюу СХД, ХУД, ЧД, БХД -т өссөн байна.

Энэрэл эмнэлэг, хорих байгууллагад илрүүлэлт өмнөх оноос өссөн байна.


БНД, БГД, БЗД, СБД зэрэг 4 (44%) дүүрэгт илрүүлэлт 20 хүрэхгүй хувьтай байна.

Хүснэгт 1.1.3 Сүрьеэгийн илрүүлэлт, 2017–2022 он

Аймаг дүүрэг	Тооцоолсон өвчлөл	Бүртгэгдсэн /шинэ+дахилт/						Илрүүлэлт					
		2017	2018	2019	2020	2021	2022	2017	2018	2019	2020	2021	2022
		тоо						хувь					
Аймгийн дүн	5237	1690	1575	1680	1459	978	1108	32.3	30.1	32.1	27.9	18.7	21.2
Багануур	94	27	31	25	17	22	9	28.7	33.0	26.6	18.1	23.4	9.6
Баянгол	1077	336	308	318	292	269	202	31.2	28.6	29.5	27.1	25.0	18.8
Баянзүрх	1927	620	573	638	616	408	366	32.2	29.7	33.1	32.0	21.2	19.0
Налайх	187	57	56	40	52	54	38	30.5	29.9	21.4	27.8	28.9	20.3
Сон.хайрхан	1968	628	550	581	585	412	415	31.9	27.9	29.5	29.7	20.9	21.1
Сүхбаатар	628	188	176	154	145	118	92	29.9	28.0	24.5	23.1	18.8	14.6
Хан-Уул	876	278	248	246	243	180	202	31.7	28.3	28.1	27.7	20.5	23.1
Чингэлтэй	956	281	275	304	250	193	254	29.4	28.8	31.8	26.2	20.2	26.6
Энэрэл	82	43	25	40	37	13	33	52.4	30.5	48.8	45.1	15.9	40.2
СЭМҮТ	-	9	0	13	11	10	14						
Багахангай	12	3	0	0	1	2	8	25.0	0.0	0.0	8.3	16.7	66.7
УБ-ын дүн	7677	2470	2242	2359	2249	1681	1637	32.2	29.2	30.7	29.3	21.9	21.3
Хорих	168	60	63	50	93	50	58	35.7	37.5	29.8	55.4	29.8	34.5
Улсын дүн	13000	4220	3880	4089	3801	2709	2803	32.5	29.8	31.5	29.2	20.8	21.6

2022 онд бүртгэгдсэн нийт шинэ сүрьеэгийн 37 хувь нь цэрний түрхцийн шинжилгээгээр, 19 хувь нь молекул биологийн болон өсгөвөрийн шинжилгээгээр онош батлагдсан бол 16 хувь нь уушгины эмнэл зүйгээр, 28% нь УБЭ сүрьеэ гэж оношлогдсон байна.


Сүүлийн 5 жилийн статистикаас үзэхэд молекул биологийн шинжилгээ /Gene Xpert/-гээр оношлогдсон хувь жил тутам нэмэгдэж байна.



Дүрслэл 1.1.1 Шинэ сүрьеэгийн оношлогдсон байдал, 2017–2022 он

Бүртгэгдсэн байдал

2022 онд мэдрэг болон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн нийт 3198 сүрьеэгийн тохиолдол (давхардсан тоогоор) бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4%(123) өссөн ба энэ нь өмнө эмчлэгдсэн тохиолдол 23% (105), мөн Р/ОЭТС тохиолдол 20% (27) тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна. Харин шинэ сүрьеэ 0.4% (10) буурсан байна.



Дүрслэл 1.1.2 Сүрьеэгийн бүртгэгдсэн нийт тохиолдол, 2017–2022

1.2 СҮРЬЕЭГИЙН ШИНЭ ТОХИОЛДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2017-2022 онд нийт 18948 сүрьеэгийн шинэ тохиолдол бүртгэгдсэний 11085 (58.5%) нь УБ хотод, 7585 (40.0%) нь аймаг орон нутагт, 278 (1.5%) нь хорих байгууллагад бүртгэгдсэн байна.

Аймаг орон нутагт бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын эзлэх хувь 2017-2019 онд өсөх хандлагатай байсан бол 2020-2021 онд буурч, 2022 онд дахин нэмэгдсэн байна.


Улаанбаатар хотод бүртгэгдсэн тохиолдлын тоо ковид цар тахлын өмнөх жилүүдэд жилд дунджаар 2100 гаруй байсан бол ковидын ид үед буюу 2020-2021 онд 1700 болж буурсан ба 2022 онд 1347 тохиолдол бүртгэгдэж бууралт хэвээр байна.

Хүснэгт 1.2.1 Сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол, 2017–2022 он

Он	Бүртгэгдсэн тохиолдол	Үүнээс:					
		Улаанбаатар хот		Аймаг		Хорих байгууллага	
		Б/тоо	Хувь	Б/тоо	Хувь	Б/тоо	Хувь
2017	3779	2211	58.5	1518	40.2	50	1.3
2018	3498	2025	57.9	1429	40.9	44	1.3
2019	3624	2073	57.2	1515	41.8	36	1.0
2020	3329	1976	59.4	1281	38.5	72	2.2
2021	2364	1453	61.5	873	36.9	38	1.6
2022	2354	1347	57.2	969	41.2	38	1.6
Нийт	18948	11085	58.5	7585	40.0	278	1.5

Шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын 10000 хүн амд ногдох түвшин сүүлийн жилүүдэд улс, аймаг, нийслэлийн түвшинд тогтмол буурч байгаа ба 2022 оны тус үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад УБ хотод буурч, аймаг орон нутагт өсөж харин улсын дундаж ижил түвшинд байна.

УБ хотын бүртгэгдсэн тохиолдлын түвшин улс болон аймгийн дунджаас тогтмол өндөр байна.



Дүрслэл 1.2.1 Сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдлын түвшин, 10000 хүн амд, 2017–2022 он

2017-2022 онд 18948 сүрьеэгийн шинэ тохиолдол бүртгэгдсэн ба үүний 11547 (60.9%) нь уушгины сүрьеэ, 7401 (39.1%) нь уушгины бус сүрьеэ байна. Нийт уушгины сүрьеэгийн дотор 8696 (75.3%) нь нян судлалаар батлагдсан сүрьеэ байна.

2022 онд шинэ сүрьеэгийн тохиолдлын дотор уушгины сүрьеэ 1699 (72.2%), уушгины бус сүрьеэ 655 (27.8%) бүртгэгдсэн нь 2021 онтой харьцуулбал уушгины сүрьеэ 258 (18%) тохиолдлоор нэмэгдэж, уушгины бус сүрьеэ 268 (29%) тохиолдлоор буурсан байна.

2022 онд шинэ сүрьеэгийн доторхи уушгины сүрьеэгийн эзлэх хувь 72.2% болсон нь 1999 оноос хойш хамгийн өндөр хувь, УБЭ сүрьеэгийн эзлэх хувь 27.8% байгаа нь 2001 оноос хойш хамгийн бага хувийг эзэлж байна.


Уушгины сүрьеэгийн доторхи нян судлалаар батлагдсан хувь жил тутам нэмэгдэж байгаа ба 2022 онд 78.1% болсон нь өнөөг хүртлэх сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааны түүхэнд хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Хүснэгт 1.2.2 Сүрьеэгийн шинэ тохиолдол, 2017–2022 он

Он	Шинэ илэрсэн сүрьеэ		Үүнээс:					
	б/тоо	10.0-д	Уушгины сүрьеэ		УБЭ сүрьеэ		Уушгины нян судлалаар батлагдсан тоо	Уушгины сүрьеэд эзлэх хувь
			б/тоо	хувь	б/тоо	хувь		
2017	3779	12.2	2080	55.0	1699	45.0	1599	76.9
2018	3498	11.1	2104	60.1	1394	39.9	1542	73.3
2019	3624	11.5	2234	61.6	1390	38.4	1637	73.3
2020	3329	10.0	1989	59.7	1340	40.3	1485	74.7
2021	2364	7.0	1441	61.0	923	39.0	1106	76.8
2022	2354	6.9	1699	72.2	655	27.8	1327	78.1
Нийт	18948	10	11547	60.9	7401	39.1	8696	75.3

Уушгины сүрьеэ оношийн ангиллаар

2020-2022 онд бүртгэгдсэн уушгины сүрьеэг оношоор нь авч үзвэл, 71.2% нь нэвчмэл, 6.1 нь голомтот, 6.0% нь хурц тархмал, 6.0% нь хөндийт, 5.4% нь сорвит хөндийт, 1.3% нь туберкулём, 4.0% нь уушгины сүрьеэгийн бусад онош тавигдсан байна.



Дүрслэл 1.2.2 Уушгины сүрьеэ оношийн ангиллаар, 2020–2022 он

Нийт уушгины сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол 2017-2019 онд өсөж байсан бол 2020-2022 онд буурсан.


2020 оноос ЭМТ302 тайлангийн маягтад өөрчлөлт орж голомтот, хөндийт, туберкулём гэсэн оношийн хэлбэрүүд нэмэгдэж орсон.

Хүснэгт 1.2.3 Уушгины сүрьеэ оношийн ангиллаар, 2017–2022 он

Он	Нийт уушгины сүрьеэ	Үүнээс:													
		Хурц тархмал		Нэвчмэл		Сорвит хөндийт		Голомтот		Хөндийт		Туберкулём		Бусад	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
2017	2080	127	6.1	1480	71.2	339	16.3							134	6.4
2018	2104	130	6.2	1560	74.1	212	10.1							202	9.6
2019	2234	101	4.5	1734	77.6	194	8.7							205	9.2
2020	1989	131	6.6	1427	71.7	114	5.7	123	6.2	95	4.8	26	1.3	73	3.7
2021	1441	85	5.9	1015	70.4	81	5.6	67	4.6	106	7.4	26	1.8	61	4.2
2022	1699	91	5.4	1212	71.3	80	4.7	121	7.1	106	6.2	16	0.9	73	4.3
Нийт	11547	665	5.8	8428	73.0	1020	8.8	311	2.7	307	2.7	68	0.6	748	6.5

Уушгины бус сүрьеэ оношийн ангилалаар

2020-2022 онд бүртгэгдсэн уушгины бус сүрьеэг оношоор нь үзэхэд, 34.5% нь уушгины гялтан хальсны сүрьеэ, 20.4% нь угийн булчирхайн сүрьеэ, 17.7% нь захын тунгалагын булчирхайн сүрьеэ, 7.1% нь нурууны сүрьеэ, 5.7% нь гэдэс хэвлийн сүрьеэ, 4.3% нь яс үений сүрьеэ, 2.1% нь сүрьеэгийн менингит, 1.9% нь шээс бэлэг эрхтэний сүрьеэ, 6.1% нь бусад сүрьеэ оношлогдсон байна.



Дүрслэл 1.2.3 Уушгины бус сүрьеэ оношийн ангиллаар, 2020–2022 он

Нийт уушгины бус сүрьеэгийн бүртгэгдэж буй тохиолдлын тоо 2017-2022 онд жил тутам буурсан үзүүлэлтэй байна.


2022 онд уушгины бус сүрьеэ 655 бүртгэгдсэн нь 1996 оноос хойш хамгийн бага тохиолдол болсон байна.

Хүснэгт 1.2.4 Уушгины бус сүрьеэ оношийн ангилалаар, 2017–2022 он

Он	Нийт уушгины бус сүрьеэ	Үүнээс:																	
		Уушигны гялтан хальсны (Плеврит)		Сүрьеэгийн Менингит		Яс, үений сүрьеэ		Шээс бэлэг эрхтэн		Угийн булчирхайн		Захын тунгалагын булчирхайн		Нурууны сүрьеэ		Гэдэс хэвлийн эрхтэний		Бусад	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
2017	1699	798	47.0	26	1.5	150	8.8	12	0.7	299	17.6	260	15.3					154	9.1
2018	1394	643	46.1	31	2.2	149	10.7	16	1.1	170	12.2	265	19.0					120	8.6
2019	1390	640	46.0	21	1.5	114	8.2	14	1.0	230	16.5	207	14.9					164	11.8
2020	1340	490	36.6	31	2.3	53	4.0	20	1.5	291	21.7	227	16.9	86	6.4	73	5.4	69	5.1
2021	923	283	30.7	17	1.8	37	4.0	20	2.2	222	24.1	152	16.5	67	7.3	55	6.0	70	7.6
2022	655	233	35.6	12	1.8	35	5.3	14	2.1	83	12.7	137	20.9	55	8.4	39.0	6.0	47	7.2
Нийт	7401	3087	41.7	138	1.9	538	7.3	96	1.3	1295	17.5	1248	16.9	208	2.8	167	2.3	624	8.4

Сүрьеэгийн шинэ тохиолдол насны ангиллаар

2017-2022 онд бүртгэгдсэн сүрьеэгийн шинэ тохиолдлыг насны бүлгээр нь үзвэл, 0-4 насанд 3.0%, 5-14 насанд 7.4%, 15-24 насанд 22.4%, 25-34 насанд 23.4%, 35-44 насанд 15.7%, 45-54 насанд 13.4%, 55-64 насанд 9.1%, 65-дээш насанд 5.5% нь бүртгэгдсэн байна.



Дүрслэл 1.2.4 Сүрьеэгийн шинэ тохиолдол насны бүлгээр, эзлэх хувь, 2017–2022 он


Сүрьеэгийн шинэ тохиолдлыг насны бүлгээр нь үзэхэд, сүүлийн жилүүдэд хүүхэд, залуу насныхан буюу 0-4, 5-14, 15-24, 25-34 насныханы эзлэх хувь буурч, харин ахмад, өндөр насныхан буюу 45-54, 55-64, 65-аас дээш насныхны эзлэх хувь нэмэгдсэн байна.

Хүснэгт 1.2.5 Сүрьеэгийн шинэ тохиолдол насны бүлгээр, 2017–2022 он

Он	Насны ангилал																Бүгд
	0-4		5-14'		15-24		25-34		35-44		45-54		55-64		65<		
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	
2017	138	3.7	286	7.6	936	24.8	948	25.1	562	14.9	438	11.6	282	7.5	189	5.0	3779
2018	91	2.6	202	5.8	882	25.2	856	24.5	530	15.2	453	13.0	289	8.3	195	5.6	3498
2019	113	3.1	269	7.4	876	24.2	858	23.7	542	15.0	486	13.4	288	7.9	192	5.3	3624
2020	112	3.4	285	8.6	691	20.8	762	22.9	539	16.2	446	13.4	313	9.4	181	5.4	3329
2021	63	2.7	228	9.6	477	20.2	535	22.6	368	15.6	324	13.7	241	10.2	128	5.4	2364
2022	46	2.0	128	5.4	384	16.3	483	20.5	439	18.6	393	16.7	316	13.4	165	7.0	2354
Нийт	563	3.0	1398	7.4	4246	22.4	4442	23.4	2980	15.7	2540	13.4	1729	9.1	1050	5.5	18948

2017-2022 онд бүртгэгдсэн сүрьеэгийн шинэ тохиолдлыг насны бүлгээр ангилж, 10000 хүн амд ногдох бүртгэгдсэн тохиолдлын дундаж түвшинг гаргахад, 0-14 нас 3.2, 15-24 нас 15.2, 25-34 нас 12.8, 35-44 нас 10.3, 45-54 нас 11.5, 55-64 нас 12.0, 65 дээш насанд 12.7 байна.

Бүртгэгдсэн тохиолдлын түвшин 10.0-д 15-24 насанд 15.2, 25-34 насанд 12.8, 65-аас дээш насанд 12.7 байгаа нь хамгийн өндөр байна.



Дүрслэл 1.2.5 Бүртгэгдсэн тохиолдлын түвшин, насны бүлгээр, 10000 хүн амд, 2017–2022 оны дундаж

2022 онд бүртгэгдсэн тохиолдлын түвшинг 2017 оны мөн үзүүлэлттэй харьцуулахад, 0-34 насанд 1.8-2.7 дахин буурсан бол 34-64 насанд 1.1-1.4 дахин, 65-аас дээш насанд 1.5 дахин буурсан байна.

Хүснэгт 1.2.6 Бүртгэгдсэн тохиолдлын түвшин, насны бүлгээр, 10000 хүн амд, 2017–2022 он

Он	0-14		15-24		25-34		35-44		45-54		55-64		65+	
	тоо	10.0-д	тоо	10.0-д	тоо	10.0-д	тоо	10.0-д	тоо	10.0-д	тоо	10.0-д	тоо	10.0-д
2017	424	4.4	936	19.6	948	16.0	562	12.2	438	12.6	282	13.5	189	15.4
2018	293	2.9	882	18.6	856	14.5	530	11.4	453	12.7	289	12.9	195	15.2
2019	382	3.7	876	18.9	858	14.7	542	11.4	486	13.4	288	12.1	192	14.2
2020	397	3.7	691	15.1	762	13.3	539	11.0	446	11.9	313	12.5	181	12.6
2021	291	2.7	477	10.5	535	9.5	368	7.3	324	8.5	241	9.2	128	8.4
2022	174	1.6	384	8.3	483	8.8	439	8.5	393	10.1	316	11.7	165	10.2

2017-2022 онд бүртгэгдсэн сүрьеэгийн нийт шинэ тохиолдлын эрэгтэй эмэгтэй хүйсийн харьцаа 1.3:1 байгаа ба насны ангилал тус бүрээр нь үзвэл; 0-14 насанд 1:1.03, 15-24 насанд 1.1:1, 25-34 насанд 1.1:1, 35-44 насанд 1.6:1, 45-54 насанд 1.9:1, 55-64 насанд 1.6:1, 65-аас дээш насанд 1:1.01 байна.


0-14 нас, 65 дээш насанд эмэгтэйчүүд бага зэрэг давамгайлсан бол бусад бүх насны ангилалд эрэгтэйчүүдийн дунд өвчлөл харьцангуй өндөр байна. Хүйсийн тоон харьцаа хамгийн их ялгаатай байгаа нь 45-54 насанд 1.9:1 байна.

Хүснэгт 1.2.7 Сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдлын тоо нас хүйсээр, 2017–2022 он

Он	0-14 нас		15-24 нас		25-34 нас		35-44 нас		45-54 нас		55-64 нас		65+		Нийт	
	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
2017	195	229	513	423	481	467	343	219	285	153	179	103	85	104	2081	1698
2018	159	134	501	381	425	431	314	216	293	160	172	117	104	91	1968	1530
2019	194	188	433	443	454	404	340	202	325	161	181	107	102	90	2029	1595
2020	191	206	365	326	393	369	318	221	283	163	191	122	80	101	1821	1508
2021	140	151	244	233	302	233	225	143	214	110	153	88	69	59	1347	1017
2022	85	89	192	192	234	249	285	154	267	126	198	118	83	82	1344	1010
Нийт	964	997	2248	1998	2289	2153	1825	1155	1667	873	1074	655	523	527	10590	8358
Хүйсийн харьцаа	1:1.03'		1.1:1		1.1:1		1.6:1		1.9:1		1.6:1		1:1.01'		1.3:1	

Хүүхдийн сүрьеэ


Нийт шинэ сүрьеэгийн тохиолдлын доторх хүүхдийн сүрьеэгийн эзлэх хувь 2017-2021 онд нэмэгдэж байсан бол 2022 онд 7.4% болж буурсан ба энэ нь сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааны түүхэнд хамгийн бага хувийг эзэлсэн байна.



Дүрслэл 1.2.6 Хүүхдийн сүрьеэгийн тохиолдлын тоо, хувь, 2017–2022 он

10000 хүн амд ногдох хүүхдийн сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдлын түвшин буурах хандлагатай байна.

2022 онд бүртгэгдсэн хүүхдийн сүрьеэгийн 10000 хүн ам дахь түвшинг 2017 онтой харьцуулахад улс, аймаг, УБ хотод жигд буурсан.



Дүрслэл 1.2.7 Хүүхдийн сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдлын түвшин, 10000 хүн амд, 2017–2022 он

Аймаг орон нутагт бүртгэгдсэн хүүхдийн сүрьеэгийн тохиолдлын түвшин 10000 хүн амд 2022 онд 0.8 байгаа нь сүүлийн 6 жилд хамгийн бага үзүүлэлт болж байна.

2022 онд хүүхдийн сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдлын түвшин аймгийн дундаж 0.8 байгаа бол Хөвсгөл (2.8), Увс (2.7), Дархан-Уул (2.1), Сэлэнгэ (1.8), Говь-Алтай (1.1), Архангай (1.0) аймгуудад аймгийн дунджаас өндөр байна. Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Ховд аймгуудад хүүхдийн сүрьеэ бүртгэгдээгүй.

Дархан-Уулаймагт 2022 онд хүүхдийн сүрьеэ 7 бүртгэгдсэн нь 2017 онтой харьцуулахад 3.7 дахин буурсан. Мөн Сэлэнгэ аймагт 2022 онд 6 тохиолдол оношлогдсон нь 2017 онтой харьцуулахад 3.3 дахин буурсан.

Хүүхдийн сүрьеэгийн өвчлөл өндөр бүртгэгддэг Дорнод, Сүхбаатар, Төв, Ховд, Хөвсгөл зэрэг аймгуудад сүүлийн жилүүдэд хүүхдийн сүрьеэгийн тохиолдол буурсан байна.

Хүснэгт 1.2.8 Хүүхдийн сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол, 2017–2022 он

Аймаг дүүрэг	Хүүхдийн сүрьеэгийн шинэ тохиолдол /0-14 нас/											
	2017	2018	2019	2020	2021	2022	2017	2018	2019	2020	2021	2022
	Тоо						10.0 -д					
Архангай	4	2	3	2	5	3	1.1	0.7	1	0.7	1.6	1.0
Баян-Өлгий	2	2	1	1	0	0	0.6	0.6	0.3	0.3	0.0	0.0
Баянхонгор	0	4	0	1	0	0	0.0	1.4	0	0.3	0.0	0.0
Булган	5	3	2	4	2	0	2.9	1.7	1.1	2.2	1.1	0.0
Говь-Алтай	1	0	2	3	1	2	0.0	0	1.1	1.7	0.5	1.1
Говьсүмбэр	3	2	1	1	2	0	3.5	3.4	1.7	1.6	3.1	0.0
Дархан-Уул	26	12	6	19	7	7	5.4	3.8	1.9	5.8	2.1	2.1
Дорноговь	1	7	4	1	2	2	0.5	3.2	1.8	0.4	0.9	0.9
Дорнод	9	5	9	4	1	0	3.2	1.9	3.4	1.5	0.4	0.0
Дундговь	5	2	2	0	0	0	3.0	1.4	1.4	0.0	0.0	0.0
Завхан	1	2	1	2	0	1	0.5	0.9	0.4	0.9	0.0	0.4
Орхон	4	5	2	2	4	3	1.0	1.6	0.6	0.6	1.2	0.9
Өвөрхангай	6	1	3	1	1	0	1.7	0.3	0.8	0.3	0.3	0.0
Өмнөговь	2	2	1	2	2	1	1.0	0.9	0.4	0.9	0.8	0.4
Сүхбаатар	11	6	8	10	9	2	6.0	3.1	4	4.8	4.2	0.9
Сэлэнгэ	20	12	13	10	7	6	5.7	3.7	4	3.0	2.1	1.8
Төв	11	6	34	4	3	2	4.0	2.1	11.9	1.4	1.0	0.7
Увс	3	1	3	2	1	8	0.7	0.4	1.1	0.7	0.3	2.7
Ховд	12	3	4	3	3	0	3.9	1	1.3	1.0	1.0	0.0
Хөвсгөл	11	11	15	7	8	2	2.2	2.6	3.5	1.6	1.8	0.5
Хэнтий	1	9	6	5	8	7	0.4	3.8	2.5	2.0	3.1	2.8
Аймгийн дүн	138	97	120	84	66	46	2.2	1.8	2.2	1.5	1.2	0.8

2022 онд хүүхдийн сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдлын түвшин Улаанбаатарын дундаж 2.5 байгаа бол ЧД (5.4), БГД (3.0), БЗД (3.0) дүүргүүдэд УБ хотын дунджаас өндөр байна.

Харин НД (0.8), СБД (0.9), СХД (0.9), ХУД (2.0) байгаа нь нийслэлийн дунджаас доогуур байна. БНД-т сүүлийн 3 жил, БХД-т сүүлийн 5 жил хүүхдийн сүрьеэ бүртгэгдээгүй байна.

2022 онд бүртгэгдсэн хүүхдийн сүрьеэгийн тохиолдлыг 2017 онтой харьцуулахад, БГД-т 2.9 дахин, БЗД-т 1.7 дахин, НД-т 5 дахин, СХД-т 3.7 дахин, СБД-т 6 дахин, ХУД-т 2.8 дахин, ЧД-т 2 дахин тус тус буурсан байна.

Хүснэгт 1.2.9 Хүүхдийн сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол, 2017–2022 он

Аймаг дүүрэг	Хүүхдийн сүрьеэгийн шинэ тохиолдол/0-14 нас/											
	2017	2018	2019	2020	2021	2022	2017	2018	2019	2020	2021	2022
	Тоо						10.0-д					
Аймгийн дүн	138	97	120	84	66	46	2.2	1.8	2.2	1.5	1.2	0.8
Багануур	0	0	2	0	0	0	0.0	0	2.3	0.0	0.0	0.0
Баянгол	70	53	44	46	41	24	10.3	7.4	6	6.0	5.2	3.0
Баянзүрх	66	38	63	84	58	38	6.6	3.5	5.4	6.9	4.6	3.0
Налайх	5	4	6	11	8	1	4.4	3.3	4.9	8.6	6.2	0.8
Сон.хайрхан	75	31	73	92	64	20	7.1	3	6.8	8.3	5.6	1.8
Сүхбаатар	24	19	8	14	11	4	5.9	4.3	1.8	3.1	2.4	0.9
Хан-Уул	43	18	36	28	17	15	6.3	3	5.6	4.1	2.3	2.0
Чингэлтэй	52	33	30	38	26	26	9.1	7	6.4	7.9	5.4	5.4
Энэрэл	0	0	0	0	0	0						
СЭМҮТ	0	0	0	0	0	0						
Багахангай	0	0	0	0	0	0	0.0	0	0	0.0	0.0	0.0
УБ-ын дүн	335	196	262	313	225	128	7.3	4.3	5.5	6.3	4.4	2.5
Хорих	0	0	0	0	0	0						
Улсын дүн	474	293	382	397	291	174	4.5	2.9	3.7	3.8	2.7	1.6

2017-2022 онд бүртгэгдсэн хүүхдийн сүрьеэгийн дотор уушгины сүрьеэ 20.3%, уушгины бус сүрьеэ 79.7% эзэлж байна.

2022 онд 0-15 насны 193 хүүхэд сүрьеэгээр өвчилсөн ба үүний 62 (32.1%) нь уушгины, 131 (67.9%) нь уушгины бус сүрьеэ байна. 2021 онтой харьцуулахад, хүүхдийн сүрьеэгийн нийт бүртгэгдсэн тохиолдлын тоо 1.6 дахин буурсан ба уушгины сүрьеэгийн эзлэх хувь өсөж, уушгины бус сүрьеэгийн эзлэх хувь буурсан байна.

Хүснэгт 1.2.10 Хүүхдийн сүрьеэгийн хэлбэр, 2017–2022 он

Он	Уушгины сүрьеэ		Уушгины бус эрхтэний сүрьеэ		Нийт
	Тоо	Хувь	Тоо	Хувь	
2017	60	12.7	413	87.3	473
2018	73	22.4	253	77.6	326
2019	115	26.8	314	73.2	429
2020	71	16.1	370	83.9	441
2021	61	19.2	256	80.8	317
2022	62	32.1	131	67.9	193
Нийт	442	20.3	1737	79.7	2179

2020-2022 онд бүртгэгдсэн хүүхдийн уушгины сүрьеэгийн 72.2% нь нэвчмэл, 7.2% нь хурц тархмал, 7.2% нь голомтот, 4.1% нь хөндийт, 2.6% нь сорвит хөндийт, 6.7% нь бусад хэлбэрийн уушгины сүрьеэ эзэлж байна.




Дүрслэл 1.2.8 Хүүхдийн уушгины сүрьеэ, оношоор, 2020–2022 он

Сүүлийн 6 жилийн статистикаас харахад, хүүхдийн уушгины сүрьеэгийн дийлэнхийг нэвчдэст сүрьеэ (63.9%-85.2%) эзэлж байна. Мөн хурц тархмал сүрьеэгийн эзлэх хувь буурахгүй байна. Хүүхдийн сүрьеэгийн дотор хөндийт болон сорвит хөндийт сүрьеэ бүртгэгдэж байгаа нь анхаарал татаж байна.

Хүснэгт 1.2.11 Хүүхдийн уушгины сүрьеэ, оношоор, 2017–2022 он

Он	Нийт уушгины сүрьеэ	Үүнээс:													
		Хурц тархмал		Нэвчмэл		Сорвит хөндийт		Голомтот		Хөндийт		Туберкулём		Бусад	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
2017	60	4	6.7	44	73.3	2	3.3							10	16.7
2018	73	3	4.1	60	82.2	0	0							10	13.7
2019	115	4	3.5	98	85.2	2	1.7							11	9.6
2020	71	7	9.9	54	76.1	0	0.0	4	5.6	2	2.8	0	0.0	4	5.6
2021	61	2	3.3	39	63.9	4	6.6	4	6.6	6	9.8	0	0.0	6	9.8
2022	62	5	8.1	47	75.8	1	1.6	6	9.7	0	0.0	0	0.0	3	4.8

2020-2022 онд бүртгэгдсэн, хүүхдийн уушгины бус сүрьеэгийн 75.7% нь угийн булчирхайн сүрьеэ, 11.6% нь захын тунгалгийн булчирхайн сүрьеэ, 5.4% нь уушгины гялтан хальсны сүрьеэ, 1.3% нь яс үений сүрьеэ, 1.5% нь сүрьеэгийн менингит, 0.8% нь гэдэс хэвлийн, 0.9% нь нурууны, 2.8% нь бусад эрхтэний сүрьеэ эзэлж байна.



Дүрслэл 1.2.9 Хүүхдийн уушгины бус сүрьеэ, оношоор, 2020–2022 он

2017-2022 оны статистикаас харахад, хүүхдийн уушгины бус сүрьеэгийн дийлэнхийг угийн булчирхайн сүрьеэ (60.1%-82.4%) эзлэх хувь байгаа ба гялтан хальсны сүрьеэ 2020-2021 онд буурч байсан бол 2022 онд дахин нэмэгдсэн байна. Мөн сүрьеэгийн менингитийн эзлэх хувь сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Гэдэс хэвлий болон яс үе, нурууны сүрьеэгийн тохиолдол бүртгэгдэж байна.

Хүснэгт 1.2.12 Хүүхдийн уушгины бус сүрьеэ, оношоор, 2017–2022 он

Он	Нийт УБЭ- ний сүрьеэ	Үүнээс:																	
		Уушгины гялтан хальсны (Плеврит)		Сүрьеэгийн Менингит		Яс, үений сүрьеэ		Шээс бэлэг эрхтэн		Угийн булчирхайн		Захын тунгалагын булчирхайн		Нурууны сүрьеэ		Гэдэс хэвлийн эрхтэний		Бусад	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
2017	413	53	12.8	3	0.7	15	3.6	2	0.5	269	65.1	52	12.6					19	4.6
2018	253	37	14.6	1	0.4	7	2.8	0	0	152	60.1	42	16.6					14	5.5
2019	314	42	13.4	0	0.0	4	1.3	0	0	211	67.2	25	8.0					32	10.2
2020	370	23	6.2	3	0.8	9	2.4	0	0	281	75.9	40	10.8	4	1.1	2	0.5	8	2.2
2021	256	6	2.3	4	1.6	0	0.0	0	0	211	82.4	24	9.4	0	0.0	4	1.6	7	2.7
2022	131	12	9.2	4	3.1	1	0.8	0	0	81	61.8	24	18.3	3	2.3	0	0.0	6	4.6

2017-2022 онд 0-15 насны 2179 хүүхэд сүрьеэгээр өвчилсөн ба үүний 25 (1.1%) нь тархмал сүрьеэ, 15 (0.7%) нь сүрьеэгийн менингитээр өвчилсөн байна. 2020 онд хурц тархмал сүрьеэгээр 7 хүүхэд өвчилсөн нь сүүлийн 6 жилд хамгийн өндөр тоо байгаа бол сүрьеэгийн менингитээр өвчилсөн хувь жил тутам нэмэгдэж байна.

Хүснэгт 1.2.13 Хүүхдийн сүрьеэгийн хүнд хэлбэрүүд, 2017–2022 он

Он	Хүүхдийн сүрьеэ	Тархмал сүрьеэ		Сүрьеэгийн менингит	
		Өвчилсөн 0-15 насны хүүхэд	Хүүхдийн сүрьеэд эзлэх хувь	Өвчилсөн 0-15 насны хүүхэд	Хүүхдийн сүрьеэд эзлэх хувь
2017	473	4	0.8	3	0.6
2018	326	3	0.9	1	0.3
2019	429	4	0.9	0	0.0
2020	441	7	1.6	3	0.7
2021	317	2	0.6	4	1.3
2022	193	5	2.6	4	2.1
Нийт	2179	25	1.1	15	0.7

Хүүхдийн сүрьеэгийн хүнд хэлбэр болох хурц тархмал сүрьеэ, сүрьеэгийн менингитээр 2017-2022 онд нийт 40 хүүхэд өвчилсөн.

Хүснэгт 1.2.14 Хүүхдийн сүрьеэгийн хүнд хэлбэр, 2017–2022 он

Сүрьеэгийн хэлбэр	2017	2018	2019	2020	2021	2022	Нийт
Хурц тархмал сүрьеэ	4	3	4	7	2	5	25
Сүрьеэгийн менингит	3	1	0	3	4	4	15

Сүүлийн 6 жилд хурц тархмал сүрьеэгээр өвчилсөн 25 хүүхдийн 9 (36%) нь 0-5 настай, 5 (20%) нь 6-10 настай, 11 (44%) нь 11-15 настай хүүхдүүд байгаа бол сүрьеэгийн менингитээр өвчилсөн 15 хүүхдийн 3 (20%) нь 0-5 настай, 7 (47%) нь 6-10 настай, 5 (33%) нь 11-15 настай хүүхдүүд байна.


Хүснэгт 1.2.15 Хүүхдийн сүрьеэгийн хүнд хэлбэр, насны ангилалаар, 2017–2022 он

Сүрьеэгийн хэлбэр	Насны ангилал																Нийт
	0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	
Хурц тархмал сүрьеэ	1	2	3	2	1	0	2	1	0	0	2	0	2	1	3	5	25
Сүрьеэгийн менингит	0	1	1	0	1	0	0	0	4	1	2	1	1	0	1	2	15

Хавьтлын үзүүлэлт


2017-2022 онд уушгины нян судлалаар батлагдсан сүрьеэтэй өвчтөний хавьтлуудын 85.5% нь эхний үзлэгт хамрагдаж, үүнээс 4.0% орчим нь сүрьеэгээр өвчилсөн болох нь оношлогдсон байна. 2021 он буюу Ковид цар тахлын ид үед хавьтлын үзлэгийн хамралт 81.2% буурсан бол 2022 онд дахин сэргэж 88.7% болсон нь сүүлийн жилүүдэд хамгийн өндөр үзүүлэлт болсон байна.

Үзлэгт хамрагдсан хавьтлын дотроос сүрьеэгээр өвчилсөн хувь сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна.




Дүрслэл 1.2.10 Уушгины нян судлалаар батлагдсан өвчтөний хавьтлын урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралт, үүнээс сүрьеэ илэрсэн хувь, 2017–2022 он

Сүрьеэгээр өвчилсөн хавьтлын дийлэх нь буюу 63% нь хүүхэд байгаа бол үлдсэн 37% нь насанд хүрэгсэд байна. 2020-2021 онд хавьтал хүүхдийн сүрьеэгээр өвчилсөн хувь өсөж 70.9%-74.2% болсон бол 2022 онд 45.7% болж буурсан байна.



Дүрслэл 1.2.11 Уушгины түрхэц зэрэг өвчтөний хавьтлаас сүрьеэгээр өвчилсөн тохиолдлын дотор насанд хүрэгчид, хүүхдийн эзлэх хувь хувь, 2017–2022 он

Нийт хүүхдийн сүрьеэгийн дотор уушгины нян судлалаар батлагдсан сүрьеэтэй өвчтөний хавьтал хүүхдийн сүрьеэгээр өвчлөх хувь жил тутам нэмэгдэж байгаа ба 2017 онд 18.8% байсан бол 2022 онд 32.6% болсон байна.



Дүрслэл 1.2.12 Хүүхдийн сүрьеэгийн дотор хавьтлаас өвчилсөн тоо, эзлэх хувь, 2017–2022он

2017-2022 онд уушгины нян судлалаар батлагдсан сүрьеэтэй өвчтөний 27416 хавьтал бүртгэгдэж, тэдгээрийн 23490 (85.7%) нь эхний урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. Үзлэгт хамрагдсан хүмүүсээс 903 (3.8%) нь сүрьеэгээр өвчилсөн болох нь оношлогдсон байна.

Сүүлийн 6 жилд 8522 хавьтал хүүхэд бүртгэгдэж, тэдгээрээс 6.4% (545) нь сүрьеэгээр өвчилсөн байна.

Урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамрагдаж буй тохиолдлын тоо нэмэгдэж байна.

Хүснэгт 1.2.16 Уушгины нян судлалаар батлагдсан сүрьеэтэй өвчтөний хавьтлын үзүүлэлтүүд, 2017–2022 он

Он	Бүртгэгдсэн хавьтлын тоо	Үүнээс: 0-15 насны хүүхэд	Хавьтлаас у/с үзлэгт орсон		Үүнээс: Сүрьеэ илэрсэн бүгд		Үүнээс: хүүхэд		У/с эмчилгээ хийлгэсэн тохиолдол
			Б/тоо	Хувь	Б/тоо	Хувь	Б/тоо	Хувь	
2017	4914	1623	4145	84.4	146	3.5	89	61.0	168
2018	4741	1359	4113	86.7	125	3.0	69	55.2	99
2019	5442	2102	4664	85.7	185	4.0	100	54.1	302
2020	3687	1296	3182	86.3	158	5.0	112	70.9	144
2021	3605	909	2929	81.2	151	5.2	112	74.2	136
2022	5027	1233	4457	88.7	138	3.1	63	45.6	280
Нийт	27416	8522	23490	85.7	903	3.8	545	60.4	1129

2022 оны хавьтал хяналтын үзүүлэлт

2020 оноос эхэлэн шинэчлэгдсэн ЭМТ302 маягтаар тайлан авч эхэлсэн ба энэхүү тайлангаар хавьтлын тоо мэдээг индекс тохиолдол тус бүрээр нь гаргадаг болсон билээ. Өмнөх жилүүдэд зөвхөн нян судлалаар батлагдсан тохиолдлын хавьтлын мэдээг гаргадаг байсан.

2022 онд сүрьеэгийн хавьтал судлалын индекс тохиолдол болох нян судлалаар батлагдсан уушигны сүрьеэ, хүүхдийн сүрьеэ, ЭТС-ийн ойрын хавьтал нийт 6255 тохиолдол бүртгэгдсэнээс 5502 буюу 88% нь сүрьеэгээс урьдчилан сэргийлэх эхний үзлэгт хамрагдсан байна.

Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүмүүсийн 3.7% (207) нь сүрьеэтэй нь оношлогдон сүрьеэгийн эмчилгээнд орсон бол 501 тохиолдол буюу 9.1% нь далд халдварын эмчилгээнд хамрагдсан байна.

Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамрагдсан 501 тохиолдлын 14% (68) нь 0-5 насны, 22% (110) нь 6-15 насны хүүхдүүд байгаа бол үлдсэн 64% (323) нь 16 ба түүнээс дээш насны хүмүүс байна.

Нийт хавьтлын 1602 (26%) нь 0-15 насны хүүхдүүд байсан ба тэдгээрийн 84%(1348) нь хавьтлын үзлэг шинжилгээнд хамрагдаж үүнээс 84 (6.2%) хүүхэд сүрьеэтэй болох нь оношлогдож эмчилгээнд хамрагдсан бол 178 (13%) нь далд халдварын эмчилгээнд орсон байна.

Хавьтлын үзлэгийн хамралт, хавьтлаас сүрьеэгээр өвчилсөн хувь, урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамрагдалт зэрэг нь ЭТС-тэй индекс тохиолдлын хавьтлуудын дунд өндөр байна.

Индекс тохиолдол тус бүрээр нь задалж үзүүлбэл:

Нэг. Нян судлалаар батлагдсан уушгины сүрьеэгийн хавьтлын үзүүлэлт

Уушгины нян судлалаар батлагдсан сүрьеэтэй өвчтөний ойрын хавьтал 5027 тохиолдол бүртгэгдсэнээс 88.6% (4457) нь хавьтлын эхний үзлэгт хамрагдсан байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хавьтлуудаас 138 (3.1%) нь сүрьеэгээр өвчилсөн болох нь оношлогдож сүрьеэгийн эмчилгээнд орсон бол 280 (6.3%) нь далд халдварын эмчилгээнд хамрагдсан байна.

Далд халдварын эмчилгээнд хамрагдсан 280 тохиолдлын 19.3% (54) нь 0-5 насны, 30% (84) нь 6-15 насны хүүхдүүд байгаа бол үлдсэн 51% (142) нь 16 ба түүнээс дээш насныхан байна.

Уушгины нян судлалаар батлагдсан сүрьеэтэй өвчтөний нийт хавьтлын 1233 (25%) нь 0-15 насны хүүхдүүд байсан ба тэдгээрийн 85% (1044) нь хавьтлын үзлэг шинжилгээнд хамрагдаж үүнээс 63 (6%) хүүхэд сүрьеэтэй болох нь оношлогдож сүрьеэгийн эмчилгээнд хамрагдсан бол 138 (13%) нь далд халдварын эмчилгээнд орсон байна.

Хоёр. Хүүхдийн сүрьеэгийн хавьтлын үзүүлэлт

Сүрьеэгээр өвчилсөн хүүхдийн ойрын хавьтал 478 тохиолдол бүртгэгдснээс 76.8% (367) нь хавьтлын эхний үзлэгт хамрагдсан байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хавьтлуудаас 21 (5.7%) нь сүрьеэгээр өвчилсөн болох нь оношлогдож эмчилгээнд орсон бол 15 (4.1%) нь далд халдварын эмчилгээнд хамрагдсан байна.

Далд халдварын эмчилгээнд хамрагдсан 15 тохиолдлын 20% (3) нь 0-5 насны, 33% (5) нь 6-15 насны хүүхдүүд байгаа бол үлдсэн 7 (47%) нь 16-аас дээш насны хүмүүс байна.

Сүрьеэгээр өвчилсөн хүүхдийн нийт ойрын хавьтлын 168 (35%) нь 0-15 насны хүүхдүүд байсан ба тэдгээрийн 82% (137) нь хавьтлын үзлэг шинжилгээнд хамрагдаж үүнээс 10 (7.3%) хүүхэд сүрьеэтэй болох нь оношлогдож эмчилгээнд хамрагдсан бол 8 (5.8%) нь далд халдварын эмчилгээнд орсон байна.

Гурав. Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний хавьтлын үзүүлэлт

Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний ойрын хавьтал 750 тохиолдол бүртгэгдснээс 90% (678) нь хавьтлын эхний үзлэгт хамрагдсан байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хавьтлуудаас 48 (7.1%) нь сүрьеэгээр өвчилсөн болох нь оношлогдож эмчилгээнд орсон бол 206 (30.4%) нь далд халдварын эмчилгээнд хамрагдсан байна.

Далд халдварын эмчилгээнд хамрагдсан 206 тохиолдлын 5.3% (11) нь 0-5 насны, 10.2% (21) нь 6-15 насны хүүхдүүд байгаа бол үлдсэн 84.5% (174) нь 16 ба түүнээс дээш насныхан байна.

Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний нийт хавьтлын 201 (27%) нь 0-15 насны хүүхдүүд байсан ба тэдгээрийн 83.1% (167) нь хавьтлын үзлэг шинжилгээнд хамрагдаж үүнээс 11 (6.6%) хүүхэд сүрьеэтэй болох нь оношлогдож эмчилгээнд хамрагдсан бол 32 (19.2%) нь далд халдварын эмчилгээнд орсон байна.


Хүснэгт 1.2.17 Сүрьеэгийн хавьтал, хяналтын үзүүлэлт, 2020–2022 он

Үзүүлэлт	Бүгд			Сүрьеэ илрүүлэх үзлэгт хамрагдсан			Үүнээс:						Сорил эерэгээс урьдчилан сэргийлэх эмчилгээ хийлгэсэн		
							Сүрьеэ оношлогдсон			Сорил эерэг					
	2020	2021	2022	2020	2021	2022	2020	2021	2022	2020	2021	2022	2020	2021	2022
Нян судлалаар батлагдсан уушгины сүрьеэгийн тохиолдлын хавьтлын тоо	3687	3605	5027	3182	2929	4457	158	151	138	301	251	112	144	136	280
Үүнээс: хүүхэд/0-5 нас/	534	343	508	496	279	408	56	38	27	140	71	32	64	47	54
Үүнээс: хүүхэд/6-15нас/	762	566	725	713	490	636	56	74	36	158	127	44	80	74	84
Хүүхдийн сүрьеэгийн нийт хавьтлын тоо	1240	997	478	1158	859	367	46	45	21	38	30	12	7	14	15
Үүнээс: хүүхэд/0-5 нас/	171	91	67	166	79	55	9	7	4	9	10	4	2	5	3
Үүнээс: хүүхэд/6-15нас/	210	150	101	204	143	82	11	14	6	30	17	7	5	9	5
Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний нийт хавьтлын тоо	1254	573	750	1066	499	678	31	18	48	55	38	26	9	17	206
Үүнээс: хүүхэд/0-5 нас/	148	70	71	144	64	61	7	3	3	29	8	8	7	6	11
Үүнээс: хүүхэд/6-15нас/	259	122	130	253	104	106	15	7	8	36	19	18	3	10	21
Нийт хавьтлын тоо	6181	5175	6255	5406	4287	5502	235	214	207	394	319	150	160	167	501
Үүнээс: хүүхэд/0-5 нас/	853	504	646	806	422	524	72	48	34	178	89	44	73	58	68
Үүнээс: хүүхэд/6-15нас/	1231	838	956	1170	737	824	82	95	50	224	163	69	88	93	110

Эмчилгээний үр дүн


2017-2021 онд бүртгэгдсэн уушгины нян судлалаар батлагдсан сүрьеэгийн шинэ тохиолдлын эдгэрэлт 78.3%, нас баралт 3.4%, үр дүнгүй 5.4%, хяналт алдагдалт 5.6%, эмчилгээний амжилт 85.3% байна.

Халдвартай шинэ сүрьеэгийн эмчилгээний үр дүн, 2017-2022 он



Дүрслэл 1.2.13 Нян судлалаар батлагдсан уушгины шинэ сүрьеэгийн эмчилгээний үр дүн, 2017–2022 он

2022 онд шинэ халдвартай сүрьеэтэй тохиолдлын эдгэрэлт 76.5%, амжилт 85.6%, нас баралт 4.0%, үр дүнгүй 4.5%, хяналт алдагдалт 5.3% байгаа нь Ковид цар тахлын өмнөх 2017-2019 оны тоо мэдээтэй харьцуулахад нас баралт өсөж, эдгэрэлтийн хувь буурсан сөрөг үзүүлэлттэй байна. Харин эмчилгээний амжилт харьцангуй тогтвортой байна.



Дүрслэл 1.2.14 Нян судлалаар батлагдсан уушгины шинэ сүрьеэгийн эмчилгээний үр дүн, 2017–2022 он

2017-2022 онд уушгины нян судлалаар батлагдсан 8969 шинэ тохиолдол эмчилгээнд хамрагдсанаас нийт 8272 тохиолдлын эмчилгээний үр дүн тооцогдсон ба үүний 5216 (78.3%) нь эдгэрч, 1842 (22.3%) нь эмчилгээ дуусгаж, 282 (3.4%) нь нас барж, 443 (5.4%) нь үр дүнгүй эмчлэгдэж, 460 (5.6%) нь хяналт алдагдаж, 29 (0.4%) нь тайлангийн хугацаанд дүгнэгдээгүй байна. Харин 697 тохиолдол нь үр дүн тооцогдоогүй (ЭТС-д шилжсэн, онош өөрчлөгдсөн, эм тохироогүй шалтгаанаар) байна.

Эмчилгээний амжилт харьцангуй тогтвортой 85.3% байгаа хэдий ч эдгэрэлтийн хувь дөнгөж 78% байгаа, мөн нас баралтын хувь нэмэгдсээр байгаад анхаарах хэрэгтэй.

Мөн нян судлалаар батлагдсан шинэ тохиолдлоос 6-7% нь эмчилгээний эхэнд болон явцад эмэнд тэсвэртэй сүрьеэ рүү шилжиж байна.

Хүснэгт 1.2.18 Нян судлалаар батлагдсан уушгины шинэ сүрьеэгийн эмчилгээний үр дүн, 2017–2022 он

Он	Уушгины шинэ нян судлалаар батлагдсан сүрьеэ	Дүгнэгдсэн	Эдгэрсэн		Эмчилгээ дуусгасан		Нас барсан		Үр дүнгүй		Хяналт алдагдсан		Дүгнэгдээгүй		Эмчилгээний амжилт	ЭТС-д шилжсэн, онош өөрчлөгдсөн, эм тохироогүй
			Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	Тоо
2017	1600	1373	1026	81.2	138	10.1	44	3.2	83	6.0	82	6.0	0	0.0	84.8	227
2018	1599	1500	1076	80.7	212	14.1	34	2.3	96	6.4	76	5.1	6	0.4	85.9	99
2019	1542	1438	859	77.1	368	25.6	46	3.2	79	5.5	79	5.5	7	0.5	85.3	104
2020	1637	1532	912	76.4	386	25.2	52	3.4	79	5.2	97	6.3	6	0.4	84.7	105
2021	1485	1376	747	77.8	433	31.5	64	4.7	59	4.3	70	5.1	3	0.2	85.8	109
2022	1106	1053	596	76.5	305	29.0	42	4.0	47	4.5	56	5.3	7	0.7	85.6	53
Нийт	8969	8272	5216	78.3	1842	22.3	282	3.4	443	5.4	460	5.6	29	0.4	85.3	697

Уушгины халдвартай хэлбэрийн шинэ сүрьеэгийн эмчилгээний амжилт 2022 онд аймаг орон нутагт 91.1%, УБ хотод 81.9%, улсын дундаж 85.6% байна.


